

УХТЭ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан 2025

УХТЭ нь 2018-2025 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан эмнэлгийг өргөжүүлэх зорилтын хүрээнд Үндэсний Оношилгоо эмчилгээний төв байгуулах төсөл амжилттай хэрэгжиж 2019 оны 07 дугаар сард бүрэн ашиглалтад оруулсан. Үндэсний оношилгоо эмчилгээний төв ашиглалтад орохтой холбогдуулан шинээр тасаг нэгжийг шилжүүлэн зохион байгуулах зорилтын хүрээнд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн эмнэлгийн даргын А/01 дугаар тушаалаар орон тоо бүтцийн шинэчлэл батлагдаж, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан стратегийн зорилтууд 95 хувьтай бүрэн хэрэгжсэн байна.

УХТЭ-ийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр буюу 2025-2029 хүртэлх стратеги төлөвлөгөө (цаашид “стратеги төлөвлөгөө” гэх)-г Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

1.3.4 Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагын нэр хаягийг монгол бичиг, кирилл бичгээр бичих асуудлыг журамлаж, стандарт мөрдүүлэн нийгмийн соёлыг дээшлүүлэх,

2.1.28 Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ,

2.2.13 Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ,

2.2.15 Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт),

2.2.26 Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ,

2.2.27 Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ,

2.2.28 Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ,

4.6.8 Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх, санхүүгийн цахим үйлчилгээ хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийнэ,

5.3.1 Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна,

Дээрх заалтуудыг үндэслэн, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсрууллаа.

Монгол улсын хөгжлийн бодлого, нийтийн эрүүл мэндийг хамгаалах бодлогуудтай уялдан хүн амын тогтвортой өсөлтийг хангах, зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, шинэ эмчилгээний арга, аргачлалыг нэвтрүүлэх боломжтой болно.

- Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа
Стратегийн тэргүүлэх чиглэл, гол зорилтуудыг Монгол улсын хөгжлийн бодлогын дараах баримт бичгүүдтэй уялдуулсан. Үүнд:
 - Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030
 - Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлого “АЛСЫН ХАРАА 2050” бодлогын Хүний хөгжил, Бүсчилсэн хөгжил, Сайн засаглал зэрэг голлох чиглэлүүдийг дэмжих, хэрэгжүүлэх байдлаар тодорхойлсон;

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2022-2026 ОНД УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

№	Дэмжиж буй бодлогын баримт бичиг	Дэмжиж буй зорилт	Хүрэх үр дүн	Хүрсэн түвшин, үр дүн
1	1.3.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагын нэр хаягийг Монгол бичиг, кирилл бичгээр бичих асуудлыг журамлаж, стандарт мөрдүүлэн нийгмийн соёлыг дээшлүүлнэ.	Төв байр, хүүхэд, уламжлалт эмчилгээний тасгийн гадна пасад, хаягжилт болон дээврийн ажлыг гүйцэтгэх	Монгол өв соёлоо хадгалсан уламжлалт монгол бичгийн хаягжилтын соёлыг нэвтрүүлнэ.	Төв байр, хүүхэд, уламжлалт эмчилгээний тасгийн гадна болон дотор хаягжилтыг Монгол болон кирилл бичгээр хаягжуулсан. УХТЭ байгууллагын тамгыг Монгол бичгээр болгож бичиг хэрэгтээ ашиглаж эхэлсэн.

2	<p>2.1.28. Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ.</p>	<p>Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолтой эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлнэ.</p>	<p>Мэргэжлийн цол зэрэгтэй, мэргэшсэн эмч, сувилагч, боловсон хүчний тоо.</p>	<p>Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирлын 2025 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн А/180 дугаар тушаалаар томилогдсон тушаалаар Мэргэжлийн зэргийн шалгалтанд Зөвлөх эмч-1, Тэргүүлэх эмч-5, Ахлах эмч- 21, Зөвлөх сувилагч-2, Тэргүүлэх сувилагч-1, Ахлах сувилагч- 6, Магистрантур-7, Докторантур-4, Магистрийн зэрэг хамгаалсан-1</p>
3	<p>2.2.13.Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.</p>	<p>Алсын зайн сургалтын төвийг хөгжүүлэх</p>	<p>Хөгжингүй орнуудын хамтын ажиллагаатай эмнэлгүүдтэй оношилгоо, эмчилгээний хүнд тохиолдлуудыг ярилцан, зайн оношилгоог хийснээр тусламж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлснээр цаг хугацаа болон эдийн засгийн хэмнэлт үүснэ.</p>	<p>Алсын зайнаас цахим технологи (www.pacs.mn) ашиглан, орон нутгийн эмнэлгүүдийн дүрс оношилгооны шинжилгээний (X-Ray, CT, MRI) мэдээлэл бүхий датаг хүлээн авч, нарийн мэргэжлийн дүрс оношилгооны эмч нар орон нутгийн дүрс оношилгооны эмч, техникч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шинжилгээний дүгнэлт бичих үйлчилгээ үзүүлсээр байна.Тус хугацаанд нийт 18 аймаг, 2 дүүргийн нэгдсэн эмнэлгүүдтэй хамтран</p>

				ажиллаж байна. Нийт дүгнэлт 3989 дүгнэлт бичсэн
4	2.2.15. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт).	Трансплантаци багийн урт болон богино хугацааны сургалтад хамруулах	Анагаахын шинжлэх ухааны шинэ дэвшилтэт эмчилгээг өөрийн оронд нутагшуулна.	Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор “Эрхтэн шилжүүлэн суулгах төв” байгуулан 5 иргэнд элэг шилжүүлэн суулгах хагалгааг 3D дурангийн аргаар амжилттай хийсэн. Эрхтэн шилжүүлэн суулгах багийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг БНСУ-ын Самсунг төв эмнэлэг, УНТЭ, ХСҮТ эмнэлгүүдэд дадлагажуулан сургаж бэлтгэсэн. Сургалтад давхардсан тоогоор 38 хүн хамрагдсан.
5		Зүрхний мэс заслыг хөгжүүлэх үндэс суурийг тавих	Зүрхний судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийгдэхтэй холбоотойгоор зүрх судасны мэс заслын 2 эмчийн орон тоог эхний ээлжинд бий болгох цаашид зүрхний мэс заслын тасгийг үүсгэн байгуулна.	Бэлтгэл ажлын хүрээнд 2 эмч, 1 сувилагч, 1 техникч нийт 4 ажилтан БНХАУ-д 3 сарын хугацаатай сургалтад хамрагдсан. Монголд "АНХ УДАА" Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээг амжилттай нэвтрүүлэн 4 хүнд мэс засал хийсэн.

6	<p>2.2.17.Яаралтай түргэн тусламжийн үндэсний тогтолцоог шинэчлэн өөрчилж, онгоц, агаарын тээврийн үйлчилгээг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.</p>	<p>Яаралтай тусламжийн тасаг бүрэн тоноглогдсон автомашинтай болно.</p>	<p>Алслагдсан бүс орон нутгаас, цаг алдалгүй, аюулгүй, эрсдэлгүй тээвэрлэлт хийж үйлчлүүлэгчийн аюулгүй байдал ажлын чанар сайжирна.</p>	<p>Яаралтай тусламжийн тасаг бүрэн тоноглогдсон автомашинтай болохоор хүсэлт хүргүүлэх ажиллаж байна.</p>
7	<p>2.2.26.Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.</p>	<p>Олон улсын жишигт нийцсэн PACS болон RIS систем дагалдах мэргэжлийн мониторуудыг хангалттай нэмэгдүүлэх.</p>	<p>Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээний чанар ахисан түвшинд хүрнэ.</p>	<p>Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь ISO 9001:20085 Чанарын удирдлагын тогтолцоо стандартыг анх 2008 онд эрүүл мэндийн салбарт анх нэвтрүүлсэн. 2009 онд Поликлиникийн тасаг анх баталгаажилт авсан бөгөөд 2010 онд эмнэлгийн хэмжээнд нэвтрүүлж 2011 онд эмнэлгийн бүх тасаг нэгжийн хүрээнд баталгаажилт авсан. 2018 онд шинэчлэгдсэн ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын дагуу үнэлгээнд хамрагдаж баталгаажилтыг авч, 2022 онд давтан баиалгаажилтаа авсан. 2025 онд олон улсын байгууллагаар дахин ISO 9001:2015 стандартыг сунгуулахаар бэлтгэл ажлын шатанд явж байна.</p> <p>Мөн MNS ISO 15189:2015 Эрүүл мэндийн лаборатори- Чанар ба чадавхид тавих шаардлага</p>

				стандартыг 2015 онд Нэгдсэн лабораторийн тасаг (клиник лаборатори, бактериологи, эмгэг судлалын хэсгүүд) баталгаажилт авсан. 2017 он, 2022 онуудад дахин баталгаажилт авсан. 2025 оны 10 дугаар сард 2024 онд шинэчлэгдсэн MNS ISO 15189:2024 стандартын баталгаажилтын үнэлгээнд хамрагдсан.
8	2.2.27.Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	Шугам хоолойг шинэчлэх	Стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 213 дугаар тушаалаар батлагдсны дагуу Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 26 өдрийн А/529 тоот тушаалаар батлагдсан хөрөнгө оруулалтын төслийн дагуу тус эмнэлэг 2024 он 12 дугаар сарын 27 УХТЭ 50 ортой эмнэлгийн шугам хоойлой, их засвар хийгдэж байна. Уг засварын ажил хийгдсэнээр иргэдэд тохь тухтай орчинд чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, эрүүл мэндийн чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

9	2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ	Цөсний замын дурангийн аппараттай болох	Цөсний замын нарийсал, хавдрын менежментэд үсрэлт авчирна	Цөсний дуран Disposable electronic choledochoscope авсан
10		Нарийн гэдэсний дурангийн аппараттай болох	Нарийн гэдэсний эмгэгүүдийн оношилгоо, цус алдалтын эмчилгээ хийгдэх боломжтой болно.	Сангийн яамны санхүүжилтээр CIT компанийн Fuji film хиймэл оюун ухаанд суурилсан уян дурангийн иж бүрдэл хүлээн авч дурангийн төвд ашиглалтад орууллаа. Дурангийн иж бүрдэл нь эмчилгээ оношилгооны хурд, чанарыг хангасан шилдэг технологи шингээсэн тоног төхөөрөмж юм.
11		Зүрхний мэс засал шинээр хөгжүүлэх бол зүрхний мэдээгүйжүүлэлтийн эмч болон холбогдох тоног төхөөрөмжөөр хангана.	Зүрх судасны мэс заслын тасагтай болж, үйл ажиллагаа жигдэрсэн байна. Шаардагдах эмч болон холбогдох тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр титэм судсан дотуурх хэт улаан туяаны болон хэт авиан аппаратны иж бүрдэл Зүрх судас судлалын тасгийн шигдээсний нэгж дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн IVUS+NIRS дүрс оношилгооны төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад оруулан Монголд "АНХ УДАА" Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээг амжилттай нэвтрүүлэн 4 хүнд мэс засал хийсэн.

12		Бөөрний эдийн шинжилгээг электрон микрокопын тусламжтай оношлох	Монгол улсад анх удаа бөөрний түүдгэнцрийн өвчнийг электрон микроскопоор оношилсноор төрөлхийн болон олдмол олон эмгэгийг оношилж эмчилдэг болно. Бөөрний дутагдалд орох өвчтөний тоо багасна, үүнтэй уялдан бөөр орлуулах эмчилгээний зардал буурна.	Сангийн яамны санхүүжилтээр Nipro брендийн NCU18 маркийн 4 ширхэг аппарат 1300-1500 цаг ажиллаж байна Электрон микроскоп ЭМЯ-наас санхүүжилт шийдэгдээгүй худалдан авалт явагдаагүй байгаа.
13	4.6.8. Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх, санхүүгийн цахим үйлчилгээ хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийнэ.	Санхүү бүртгэлийн анхан шатны баримт бичгийг цахимжуулах	Дижитал Монгол бодлогыг дэмжиж цахим бүртгэлийн нэгдсэн системд холбогдоно.	Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж Интерактив ХХК Эмералд программ ашигладаг. Санхүү бүртгэлийн анхан шатны баримт бичгийг цахим бүртгэлээр бүртэж байна. Санхүүгийн цахим үйлчилгээ хөгжүүлэх чиглэлээр /shilendans.gov.mn/ тайлан мэдээлэлээ оруулж байна. Эм эмнэлгийн хэрэгсэл бүртгэлийг Карте бүртгэлийн программаар бүртгэж байна. Эмнэлгийн албан ёсны цахим

				хуудасны (www.ssch.gov.mn) "Ил тод байдал" хэсгийн "Санхүүгийн ил тод байдал хэсэгт Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж /хуульчилсан акт/ дүрэм, журам, заавар жагсаалт, байгууллагын ил тод байдлын тайланг байршуулан ажиллаж байна.
14	5.3.1.Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.	Цахим гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлнэ.	Цахим гарын үсгийг нэвтрүүлсэн байна. Үйл ажиллагаа хэрэгжилт жигдэрсэн байна.	Мэдээллийн аюулгүй байдлын хувь хүний мэдээллийн аюулгүй байдал цахим засаглалыг хөгжүүлэх үүднээс Ерөнхий захирал Etoken ашиглан гарын үсгийн баталгааг хангаж байна

